## “ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ТАЙЛАН

Орхон аймаг 2025 оны 12 дугаар сарын 05

| № | Үйл ажиллагаа | Суурь түвшин /2024 он/ | Хүрэх түвшин /2025 он/ | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| **Зорилго:** Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих бодлого эрхзүй, нийгэм-эдийн засгийн таатай орчинг бэхжүүлж, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, эх, хүүхдэд зонхилон тохиолдох сэргийлж болох өвчин эмгэг, түүний хүндрэлийг багасгах замаар эх, хүүхдийн өвлөл, эндэгдлийг тогтвортой бууруулах. | | | | | |
| Зорилт 1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих бодлого, эрхзүй, нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн, бусад салбар, төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, орон нутгийн шийдвэр гаргагчдын оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжин, уялдаа холбоог сайжруулах. | | | | | |
| 1.3 | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр мөрдөгдөж буй журам, зааврыг үйлчилгээ үзүүлэгчид таниулах, тархаах ажлыг зохион байгуулах. | 2 | Эх, хүүхэд, НҮЭМ-ийн чиглэлээр мөрдөгдөж буй журам, зааврын жагсаалтыг гаргасан байна. | Эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжиж буй хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЭМС-ын тушаал, заавар, хууль эрхзүйн баримт бичгийн товъёог үүсгэн Эрүүл мэндийн салбар байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. “ Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, салбаруудад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭМС-ын 2024 оны А/292 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд салбар дундын хэлэлцүүлэг - 1, танхимын сургалт 3 удаа зохион байгуулж 10 байгууллагын давхардсан тоогоор 68 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулсан. | 100 |
| 1.4. | Эх хүүхэд НҮЭМ-ийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж ,эм эмнэлгийн хэрэгслийн хангалт, засвар үйлчилгээг тасралтгүй хийх тогтолцоог бүрдүүлж санхүүжилтийг шийдвэрлэх | 75,0% | 85,0% | Тайлант хугацаанд БОЭТ-ийн төрөх,эмэгтэйчүүдийн тасаг нь үзүүлсэн тусламж үйлчилгээгээрээ Эрүүл мэндийн даатгалаас нийт 2.678.0 сая төгрөгийн санхүүжилт авсан нь сүүлийн 4 жил тогтвортой өссөн дүнтэй байгаа бөгөөд архаг өвчний квот хангалтгүйн улмаас эмэгтэйчүүдийн өвчлөл архаг оношид ордогтой холбоотой дурангийн хагалгааны тоо цөөрөх шалтгаан болж байна.Төрөх,эмэгтэйчүүдийн тасгийн тоног төхөөрөмжийн хангалт 83%-тай байгаа бөгөөд цаашид оношилгоо, тусламж үйлчилгэний нэр төрөл, хүчин чадлыг сайжруулах чиглэлээр ургийн зүрхний бичлэгийн аппарат, дуслын памп дурангийн багаж, эхо аппаратны хүчин чадлыг сайжруулах, хагалгааны өрөөг вакуум болгох саналыг эрэмбэлэн төсөвь тусгуулаад байна.<br>2026 онд орон нутгийн 2,2 тэрбум төгрөгний санхүүжилтээр төрөх тасгийн их засварыг хийгдэхээр төсөв батлагдсан байна.<br>БОЭТ-ийн Нярайн тасгийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 85,6% | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хувьтай ба тариурын болон дуслын автомат шахуурга шаардлагатай байна. Тайлант хугацаанд НҮБХС, ЭМЯ-аас 14.5 сая төгрөгийн санхүүжилтээр нярайн эрт илрүүлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг (хөдөлгөөнд тэсвэртэй пульскосиметр 17 ширхэг, арклайт 5 ширхэг) нярайн тасагт хүлээлгэн өгсөн. Хүүхдийн тасгийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 80%-тай ба амьсгалын аппарат, монитор дутагдалтай байна.<br>Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн эргэлтэд ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 дугаар тогтоолоор эх, нярайн гэрийн эргэлтийн тарифыг 100,000 төгрөг болгож шинэчлэн тогтоосон. | |
| 1.5 | Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтын тасралтгүй байдлыг ханган нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгч жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгслийн сонголт хийх боломжийг олгож, 5-аас доошгүй нэр төрлийн, 3-аас доошгүй сарын нөөцийг бүрдүүлсэн байх. | 66,1 | 66,3% | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж буй нийт 16,297 эмэгтэй (66.3%) байгаа нь оны өмнөх үеэс 419 тохиолдлоор нэмэгдсэн байна. Тайлант онд 1295 эмэгтэй жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслээ зогсоож, 1714 эмэгтэй шинээр жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж байна. Жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн төрлөөр авч үзвэл хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн 2901 буюу 17.8% нь жирэмслэлтээс хамгаалах эм, 1535 буюу 9.4% нь тариа, 797 буюу 4.9% нь суулгац, 4603 буюу 28.2% нь бэлгэвч, 4921 буюу 30.2% нь ерөндөг, 372 буюу 2.3% нь гуурсан хоолой боох ажилбар, 1168 буюу 7.2% нь бусад байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн 1 сарын нөөцтэй байна. ЖСА хэрэглээний тайлан, нөөцийн мэдээллийг ЭХЭМҮТ-ийн Тандалт судлалын албаны цахим программд цаг тухай бүрт нь мэдээлэн ажиллаж байна. | 100 |
| 1.7 | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээрх нэн шаардлагатай судалгаа, эрдэм шинжилгээний хэрэгцээг гарган, тэргүүлэх чиглэлийг тогтоож, санхүүжилтийг шийдвэрлэн, захиалгат судалгааны ажлыг хийх байгууллага, судлаачийг сонгон шалгаруулж, судалгаа хийлгэн, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах. | 6 | Нэн шаардлагатай судалгааны ажлын жагсаалтыг гаргаж, албажуулсан байна. | Тайлант хугацаанд Орхон аймгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүйн боловсролын чиглэлээр 2, ургийн оношилгоо, ховор тохиолдлоор 2, төрөх болон төрсний дараах тусламж үйлчилгээний чиглэлээр 2, эмэгтэйчүүдийн чиглэлээр 2 практик ач холбогдол бүхий 8 судалгаа хийгдэж, байгууллага, аймгийн эмч нарын эрдэм шинжилгээний хурал, өрхийн анагаах ухааны холбооны эрдэм шинжилгээний хурлуудад тэргүүн байр эзэлсэн, олон улсын хуралд ханан илтгэлийн хэлбэрээр судалгааны үр дүнг амжилттай танилцуулсан байна. Хийгдсэн судалгаанууд:<br>● "Эх, нярайн эрүүл мэндийн дэлхийн платформ"-ын судалгааг БОЭТ-ийн төрөх тасагт 461 эхийн судалгааг авч боловсруулсан.<br>● Төрсөн эхчүүдийн төрсний дараах сэтгэл гутралд өртөх эрсдлийг Эдинбургийн сорилоор илрүүлэх нь<br>● Умайн хүзүүний хорт хавдрын эрт үеийн оношилгоонд хиймэл оюун ухаанд суурилсан CerviCare AI системийн үр дүнг судлах нь<br>● Орхон аймгийн ургийн эхний 3 сарын тархины BS, BSOB-ын хэвийн | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хэмжээг тогтоох нь<br>● Ургийн Arnold Chiari II malformation-ийн тохиолдлын танилцуулга<br>● Үйлсбадрах ӨЭМТ-өөр үйлчлүүлж буй зарим эмэгтэйчүүдэд цэвэршилтийн хамшинжийн үед зонхилон тохиолдох эмнэлзүйн шинжийг тодорхойлсон нь<br>● Орхон аймгийн ЕБС-ын III, IV-р сургуулийн өсвөр насны зарим сурагчдын дунд бэлгийн боловсролыг тодорхойлсон нь<br>● Жаргалант сумын ЕБС-ын 7-12-р ангийн охидын жирэмслэлтээс хамгаалах аргын талаарх мэдлэг хандлагыг үнэлэх нь байна. | |
| 1.8 | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээнд шинээр нэвтрүүлэх, нутагшуулах, үйл ажиллагааг өргөжүүлэх, үр дүнтэй, өртөг багатай арга аргачлал, интервенцийг холбогдох бодлогын баримт бичигт тусгах | 1 | Тухайн жилд оношилгоо, эмчилгээнд шинээр нэвтрүүлэх арга аргачлал, заавар, журам батлагдсан байна. | Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ургийн гажгийн оношилгоо хийх пренатологич эмч орон тоогоор ажиллаж эхлэн тайлант хугацаанд нийт үзлэг 1357 хийгдсэнээс өвчний учир 928 (68%), идэвхитэй хяналтаар 429 (32%) эхэд үйлчилсэн байна. Жирэмсний эрт үеийн нийлмэл илрүүлэгт 141 хүн үзсэнээс эрсдэл өндөр 20 үйлчлүүлэгчийн 13 эмэгтэйг NIPT шинжилгээнд, 5 эмэгтэйг ургийн усны шинжилгээнд хамруулж, эрт хугацаанд эрсдэл өндөр ургийн эрхтэн системийн гажигшилтай 2 эхийн жирэмслэлтийг эрт хугацаанд шийдсэн.16-17 долоо хоногтой Soft marker илрүүлэх ЭХО оношилгоо 137 эмэгтэйд хийж, 18-22 долоо хоногтой ургийн бүтцийн ЭХО давхардсан тоогоор 270 гаруй эмэгтэйд хийснээс олон урагтай жирэмсэн-18 дээд шатлалд-7 эмэгтэй илгээсэн. Тайлант хугацаанд RH-цустай жирэмсэн эмэгтэйн хяналт үзлэг-2, ургийн зүрхний эмгэг-4 VSD-2 fetal arrhythmia-2, ургийн амьсгалын эрхтний гаж хөгжил-1, бөөр шээсний замын эмгэг-2, ургийн төв мэдрэлийн эмгэг-3, ургийн мөчдийн эмгэг-1 илрүүлэн 3 дугаар шатлалд илгээн жирэмслэлт тээлтийг шийдүүлсэн. Мөн эмэгтэйчүүдийн дурангийн 2 эмч ажиллаж, эмэгтэйчүүдийн мэс засал, ажилбаруудыг хийж гүйцэтгэж байна.<br>Бүсийн оношилгоо эмчилгээний төвд тайлант хугацаанд 228 эмэгтэйчүүдийн хагалгаа хийгдсэнээс дурангийн хагалгаа 34 (14.9%) хийгдсэн байна. БОЭТ-ийн төрөх тасаг Нийслэлийн Өргөө амаржих газрын "Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг"-тай хамтран орон нутагт анх удаа дурангаар умай бүтэн авах (TLH) ажилбар хийгдсэн.Баян-Өндөрмед нэгдсэн эмнэлэгт умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хиймэл оюун ухаанд суурилсан Cervicare AI систем, GMD-S600 үтрээний шүүрлийг оношлох автомат анализатороор 17 үзүүлэлтээр нарийвчилсан шинжилгээг хийж байна. Эрдэнэт Медикал эмнэлэг 2024 онд үйлдвэрлэгдсэн GE Volusion E6 эхо аппаратаар жирэмсний хяналтын эхо шинжилгээг үзүүлж байна. | 100 |
| **2** | **Зорилт 2. Эх, ураг, нярайн эрт үеийн тусламж, үйлчилгээнд нотолгоонд тулгуурласан үр дүнтэй үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэлхийн хөгжингүй улс орнуудад нэвтрүүлж буй шинэ арга технологийг нутагшуулах, тусламж, үйлчилгээний байнгын бэлэн байдлыг хангах, төвлөрлийг сааруулж, хүртээмжийг нэмэгдүүлэн, чанарыг сайжруулж, эх, ураг, нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах.** | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2.1 | Эх, нярайд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн үзүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх (Жирэмсний болон төрсний дараах үеийн хяналт, БНХХ-ийг дэмжих үйл ажиллагааг эрүүл мэндийн анхан шатны бусад тусламж үйлчилгээтэй уялдуулах, амаржих газар, нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг хөгжлийн чиг хандлага бодлоготой уялдуулан чиглүүлэх.) | | ЭМ-ийн даатгалын сангаас санхүүжүүлэх санхүүжилтийн жагсаалтыг ЭМАШТҮ үзүүлэгчдийн саналыг тусгаж, шинэчлэн боловсруулсан байна. | Тайлант хугацаанд анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 1453 эмэгтэйг шинээр жирэмсний хяналтад авч, үүнээс эрт үеийн хяналтад 99%-ийг авч өмнөх оны мөн үеэс 0.3%-иар буурсан байна. Жирэмсний болон төрсний дараах тусламж үйлчилгээг ЭМС-ын 2024 оны А/292 дугаар тушаалын дагуу гүйцэтгэж, өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн кабинетад 2016 эхийг шилжүүлсэн ба 1-р бүлэг -151 (7.6%), 2-р бүлэг - 1224 (61.9%), 3-р бүлэг - 407 (20.6%), 4-р бүлэг - 196 (9.9%) байв.<br>Тайлант хугацаанд 1761 эмэгтэй төрсөн ба төрсөн эмэгтэйчүүд жирэмсний хяналтад 6 ба түүнээс дээш хамрагдсан эх -1659 буюу 94.2 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 22%-иар нэмэгдсэн байна.Төрсний дараах эх, нярайн гэрийн эргэлтийг ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 дугаар тогтоолд эмнэлэгт ирэх боломжгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрсний дараах эх, нярай, хүүхдэд гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний тарифыг шинээр тогтоож, хэрэгжилт хангагдан ажиллаж байна. | 100 |
| 2.2 | Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдэд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахыг байгуулан эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн 6 сарын нөөцийг бүрдүүлэх. | | Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгсэл, бичил тэжээл, ЖХАХ-ийн жагсаалт гаргасан байна. | Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд орон нутгийн хөрөнгө оруулалтаар вакцины агуулах баригдаж байна.Тайлант хугацаанд тасалдсан эм, эмнэлгийн хэрэгсэл байхгүй.Денк фармын өвчин намдаах лаа буцаан татаж, оронд нь өөр лаа олгосон.Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөцтэй. Үүнд:<br>- Амиллуулах тусламж үйлчилгээний 6 төрлийн 586 эм<br>- Нянгийн эсрэг 20 төрлийн 26,673 ширхэг эм<br>- Вирусын эсрэг 3 төрлийн 650 эм<br>- Дуслын шингэн 3706<br>- Өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвсэл намдаах 8 төрлийн 9070 эм<br>- Эм, эмнэлгийн хэрэгсэлд N95 маск - 200 ш, эмнэлгийн нэг удаагын амны хаалт - 20,000ш, утлагын аппарат - 5ш, хамрын ац гуурс - 100ш, халуун хэмжигч -10ш нөөцөд байна.<br>Мөн ЭМГ-ын гамшиг, яаралтай үеийн бэлэн байдлыг хангах нөөцөд эм, эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөц байна. | 70 |
| 2.3 | | | | | |
| 2.4 | Нярайг ангир уургаар эрт амлуулах, эхийн сүүгээр хооллоход мэргэшсэн дэмжлэг, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг төрөх, нярай, хүүхдийн тусламж, | Магадлан итгэмжлэлийн шалгуурт зарим үзүүлэлтүүд тусгагдсан. | "Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 | Тайлант хугацаанд 1761 эх амаржиж, 1774 нярай төрсөн ба төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд 99.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар нэмэгдсэн байна. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхам"-ын сургалтыг БОЭТ-ийн нярайн тасагтай хамтран онолын хэсэг, багаар ажиллах, дүрд тоглох, эмнэлзүйн дадлага гэсэн байдлаар 2 өдөр зохион байгуулсан.Сургалтад БОЭТ-ийн төрөх, хүүхэд, нярайн тасгийн эмч, | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагад түгээн дэлгэрүүлэх *(эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхам, хөхний арчилгааны тусламж)* | | алхам"-ыг холбогдох ЭМБ-ын стандарт, магадлан итгэмжлэлийн шалгуурт өөрчлөлт оруулж, шалгуурыг тусгасан байна. | сувилагч, сум өрхийн эрүүл мэндийн төсвийн нийт 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулж,эцэг, эх асран хамгаалагчдад эхийн сүүгээр хооллолтын ач холбогдол, ангир уураг,хүүхдийг зөв тэврэх,хөхүүлэх талаар зөвлөгөө өгөх мэдлэг, ур чадварыг сайжруулсан.<br>- Өрхийн эрүүл мэндийн төвүүд "Ээжүүдийн клуб"-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, 6-10 төрлийн сэдвийн хүрээнд 31 удаагийн сургалтад давхардсан тоогоор 979 жирэмсэн болон хөхүүл эхчүүд, бага насны хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулан эрүүл мэндийн боловсрол олгож эх, хүүхдийн эрүүл мэнд, асаргаа, хоол тэжээл, хөх арчилгаа, жирэмсний хяналтын ач холбогдлын талаар эрүүл мэндийн боловсрол олгож, тэдний мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. | |
| 2.5 | Эх барихын тусламж, үйлчилгээний чанарт хүний нөөцийн тасралтгүй сургалтын орчинг бүрдүүлж, эх барихын яаралтай цогц, тусламж үйлчилгээний чиглэлээр эмч, мэргэжилтэн ажлын байрны богино хугацааны сургалтад сургаж дадлагажуулах. | Аймаг нийслэлийн зөвлөх эмч нарыг сургасан. | Сургалтын хөтөлбөр боловсруулсан байна. | Тайлант хугацаанд танхимын 8 сургалтад 55 их эмч, 12 эх баригч хамрагдсан байна. Үүнд:<br>● ЭМЯ, ЭХЭМҮТ-ээс зохион байгуулсан "Жирэмсний эрт үеийн илрүүлэг (НИПТ шинжилгээ)" сэдэвт 1 өдрийн сургалтад БОЭТ-ийн пренатологийн эмч,<br>● Эх барих, эмэгтэйчүүдийн нийгэмлэгийн ээлжит хурал, уулзалт, сургалтад 2 эмч,<br>● Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ сэдэвт сургалтад 1 эмч,<br>● Хүний папиллома вирусын эсрэг дархлаажуулалтын үеийн харилцаа холбоо ба умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтад 6 их эмч,<br>● Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээ сургалтад 12 их эмч, 3 эх баригч<br>● ЭМГ-аас жирэмсний хяналт, эрсдлийн үнэлгээ, эх баригч нарыг чадавхжуулах сургалтыг 3 удаа 22 их эмч, 9 эх баригчид зохион байгуулсан.<br>**Цахим хурал, сургалт:** ЭХЭМҮТ-ээс зохион байгуулсан 7 удаагийн цахим хурал, сургалтад 11 байгууллагын төлөөлөл бүрэн хамрагдсан.<br>**Олон улсын хурал, сургалт:** Орхон аймгийн 4 эх барих, эмэгтэйчүүдийн эмч Японы эх барихын нийгэмлэгийн 3 өдрийн хэт авиан оношилгооны сургалтад хамрагдсан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2.7 | Жирэмсэн эмэгтэй, эх, нярайд тохиолдох аюултай шинжийг эрт илрүүлэх, яаралтай тусламж, эх барихын үжил, жирэмсний хяналт, төрсний дараах эх, нярайн гэрийн эргэлт, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр өрх, сумын эмч, эх баригч нарыг сургаж, дадлагажуулах (АНЭ дээр 14 хоногийн ажлын байрны сургалтад хамруулах) | Зарим аймгуудад хэрэгжүүлж байна. | Сургалтын хөтөлбөрийг боловсруулж, баталгаажуулсан байна. Сургагч багш нарыг бэлтгэсэн байна. | Өрхийн эрүүл мэндийн төвийн 8 эх баригчийн ажлын 5 хоногийн хугацаатай БОЭТ-ийн өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн кабинетад сэлгэн ажиллуулж ажлын байран дээр дадлагажуулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх тасгийн 24 эх баригч, эмчийг Эх нярайн үндэсний төв II-ийн төрөх тасагт 2 сарын турш ээлжлэн туршлага судлуулан дадлагажуулсан байна.<br>АШУҮИС-ын Дархан-Уул аймгийн салбарын сувилахуйн сургуулийн эх барихын багш нар сум, өрх, БОЭТ-ийн 30 эх баригчийг жирэмсний хяналт, гэр бүл төлөвлөлт, эх барихын яаралтай тусламж зэрэг 4 онол, 4 дадлагын сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 2.8 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны өвчин эмгэгийг эрт илрүүлэн, эрүүлжүүлэх, жирэмслэлтэд бэлтгэх үйл ажиллагааг тогтмолжуулах, олон улсын байгууллагаас өгч буй зөвлөмжийн дагуу жирэмслэхээс өмнөх үзлэг шинжилгээний багцыг боловсруулж, хэрэгжүүлэх. | Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 50% | Үзлэгт хамрагдвал зохих НҮ-ийн насны эмэгтэйчүүдийн тоо, мэдээг ӨЭМТ, СЭМТ бүр гаргаж, үзлэгийг эхлүүлсэн байна. | Орхон аймагт нөхөн үржихүйн насны 25,030 эмэгтэй байгаагаас урьдчилан сэргийлэх үзлэгт 14,626 буюу 58.4% нь хамрагдсан байна. Тайлант хугацаанд умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг үзлэгт 5764 эмэгтэйг хамруулахаар төлөвлөснөөс 5033 эмэгтэй буюу 87.3 хувийг хамруулсан байна. Үүнээс пап шинжилгээ өөрчлөлттэй гарсан 66 эмэгтэйгээс хавдрын урьдал эмгэг илэрсэн 2 эмэгтэй байна. Хөхний өмөнгийн эрт илрүүлэгт 24,454 эмэгтэйг хамруулахаар төлөвлөснөөс 19,236 эмэгтэй буюу 78.6 хувийг хамруулж, өөрчлөлттэй илэрсэн 1 эмэгтэйг лавлагаа шатлал руу онош тодруулахаар илгээжээ.<br>Сум, өрхийн эрүүл мэндийн төв, 1 сумын эрүүл мэндийн төв, Амурлин Тэнгис ТББ, Мишээл НЦО, Хатагтай эмнэлгүүдтэй хамтран зорилтот бүлгийн 1496 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан ба БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээнд 812 эмэгтэй, охидод зориулсан эхо оношилгоог 711 эмэгтэйд хийж, 192 (13%) өвчлөл илрүүлж, эмчилгээ хяналтад авсан байна.<br>Үйлсбадрах ӨЭМТ O23.9 Жирэмсэн үеийн шээс бэлгийн замын бусад ба тодорхой халдвар оношоор өдрийн эмчилгээний багц гаргаж, нийт жирэмсний хяналтад байгаа 55 эхийг эмчлэн эрүүлжүүлсэн. Нийцэл ӨЭМТ 182 жирэмсэн эмэгтэйд хүчилтөрөгчийг коктейль өгчээ. | 90 |
| 2.9 | Эх барихын үжлийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх эмнэлзүйн заавар, хяналтын хуудсыг нотолгоод тулгуурлан шинэчлэн боловсруулж | | Заавар, маягтын төслийг бэлтгэж, сорил хийсэн байна. | Эх барихын үжлийн оношилгоо, эмчилгээний зааврын цахим сургалтад ЭМГ-ын мэргэжилтэн, БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч нар хамрагдаж, эх барихын үжлийн оношилгоо, эмчилгээний зааврын төслийн хэлэлцүүлэгт БОЭТ-ийн төрөх тасгийн эрхлэгч хамрагдан чадавхжсан байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | мөрдөх. | | | | |
| 2.11 | Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эх, бага насны хүүхдийг олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлээр хангах, эхэд хоол, тэжээлийн тусламж үйлчилгээ үзүүлэх тухай ДЭМБ-ын зөвлөмжийг холбогдох журам, зааварт тусган хэрэгжүүлэх, ОНБТБ-ийг нэн шаардлагатай эмийн жагсаалтад оруулж, эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож хэвших. | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/197 тоот, 2024 оны А/292 тоот тушаал | Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулна. Шинэчлэн батлуулсан журам, заавар, жагсаалтыг ЭМБ-д танилцуулж, сурталчилна. | Аймгийн засаг Даргын 2025 оны “Хөрөнгө гаргах тухай” А/384 захирамжаар батлагдсан орон нутгийн 10 сая төгрөгийн санхүүжилтээр эм ханган нийлүүлэх байгууллагуудаас 90 ширхэгтэй 295 савлагаатай Жентли Айрон бэлдмэлийг авч, Эрүүл мэндийн газрын даргын А/46 дугаар тушаалаар сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдүүдээр дамжуулан Нийгмийн халамж нэн шаардлагатай 535 жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд буюу зорилтот бүлгийн 32.5%-д Жентли Айрон бэлдмэлийг 1-2 сарын хэрэглээг олгож үр дүнг тооцон ажиллаа. Уг бэлдмэлийг цус багадалттай – 181 (33.8%), эх барихын ужиг дурьдатгалтай – 86 (16.1%), эх барихын бус бусад эмгэгтэй – 85 (15.9%), нийгмийн халамж нэн шаардлагатай – 111 (20.7%), хөхүүл эх – 72 (13.5%) тус тус олгосон байна.<br>НҮБ-ийн Хүүхдийн сангаас олгосон 1692 жирэмсэн эхийн олон найрлагат бичил тэжээлийн холимогийг ЭМГ-ын даргын А/80 дугаар тушаалаар хуваарилан 989 жирэмсэн эхэд эхний 2 сарын амин дэмийг олгож,хэрэглээнд хяналт тавин ажилласан. | 100 |
| 2.13 | Нярайн цогц скрининг шинжилгээг эрчимжүүлж, тогтмолжуулах. | Нярайн цогц скрининг 6 хувь | Нярайн цогц скрининг хийх чиглэлээр эмч мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулна. Санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. | Тайлант хугацаанд 1761 эх төрсөн бөгөөд өмнөх оны мөн үеэс төрөлтийн тоо 65 тохиолдлоор буурсан байна.<br>-НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр АШУҮИС-ийн “Нярайн скринингийн салбар төв”-ийг БОЭТ-ийн нярайн тасагт байгуулан, төрсөн нярай бүрт 5 төрлийн эрт илрүүлэг нярайн скрининг оношилгоо 100% хийгдэж байна.<br>- “Нярайн цогц скрининг шинжилгээг нутагшуулах нь” эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг ЭМЯ, НҮБХС, Нярайн цогц скринингийн үндэсний багтай хамтран зохион байгуулж, Орхон, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв нийт 5 аймгийн 6 эрүүл мэндийн байгууллагын 19 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан. НҮБХС, ЭМЯ-аас 14.5 сая төгрөгийн санхүүжилтээр нярайн эрт илрүүлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг (хөдөлгөөнд тэсвэртэй пульскосиметр 17 ширхэг, арклайт 5 ширхэг) нярайн тасагт хүлээлгэн өгсөн.<br>- Тайлант хугацаанд төрсөн 1774 нярайг 5 төрлийн эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд хамруулсан.<br>- Нярайн түнхний дутуу хөгжлийн эрт илрүүлгийн эхо оношилгоонд 1771 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | буюу 99.8%-ийг хамруулж, давтан оношилгоонд 1565 нярай хамрагдсан. Үүнээс түнхний дутуу хөгжилтэй нярай илрээгүй.<br>- Нярайн төрөлхийн дүлийрэл, сонсол бууралтын эрт илрүүлэгт 1111 буюу 62.6%-ийг хамруулж, үүнээс 65 (5.8%) нярайд давтан үзлэг хийж, чих хамар хоолойн эмчид 2 нярайг илгээж, хяналтад авсан.<br>- Нярайн скрининг бодисын солилцооны 5 төрлийн эмгэгийн эрт илрүүлэгт 1347 буюу 75.9%-ийг хамруулж, өсгийний хатгаасан цусны толбоны шинжилгээг 7 хоног бүр нярайн скрининг оношилгооны лабораторид илгээж байна. Үүнээс давтан шинжилгээнд 40 (2,9%) нярайг хамруулж, өөрчлөлт илэрсэн 1 нярайг хяналтад авсан.<br>- Орбис ОУБ-ын санхүүжилтээр, ЭХЭМҮТ-тэй хамтран “Хүүхдийн нүдний хавдрыг илрүүлэх улаан рефлексийн аргыг” нэвтрүүлсэн. Гүйцэт нярайн нүдний эмгэгийн эрт илрүүлэгт 1772 нярай буюу 99.8 хувийг хамруулсан бөгөөд эмгэг илрээгүй.<br>- Дутуу нярайн ретинопатийн оношилгоонд 31 нярайг хамруулж, давтан үзлэгт давхардсан тоогоор 62 нярай хамрагдсан байна. Үүнээс 3 нярайг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд илгээж, хяналтад авсан.<br>- 2025 оны 10-р сараас эхлэн нярайн пульсоксиметрийн скринингийг нярайн тасагт нутагшуулан зүрхний төрөлхийн гажгийг эрт илрүүлэх скринингт 332 нярай хамрагдаж, зүрхний эмгэг илрээгүй байна. | |
| 2.15 | Эхийн хоол тэжээлийн тусламж, үйлчилгээний талаар эрүүл мэндийн мэргэжилтэнд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулан сургалт зохион байгуулах. | ЭМА-д зориулсан гарын авлага байхгүй | Гарын авлага боловсруулж хэвлүүлнэ. Хоол тэжээлийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний чиглэлээр үндэсний сургагч багш бэлдэнэ. | Эхийн хоол тэжээлийн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс Дархан-уул аймагт зохион байгуулагдсан төвийн бүсийн сургалтад Орхон аймгийн 3 эмч,эмнэлгийн мэргэжилтэн оролцож, орон нутагт хоол тэжээлийн үндэсний 3 сургагч багш бэлтгэгдэн, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 33 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2 удаа, иргэд олон нийт болон төрийн албан хаагчдад "Амьдралын алтан 1000 хоног" сэдэвт сургалтыг 215 хүнд зохион байгуулсан байна. | 70 |
| 2.20 | Нярайн өвчлөл, эндэгдлийг | Сурфактант | Оношилг | -Орон нутагт сурфактант эмчилгээг 2015 оноос эхлэн нярайн тусламж | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бууруулах үндэсний багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ураг, нярайн амьдралын чанарыг дээшлүүлэхэд нэн шаардлагатай эмчилгээ, оношилгоог нэвтрүүлэх, цахим эх, хүүхдийн бүртгэлд нэмж оруулах, үр дүнг хянах тогтолцоог бий болгох, төвлөрсөн мэдээллийн санд их өгөгдөлд нийлүүлэх (тархи хөргөх, сурфактант, нитрикоксид эмчилгээ, пульсоксиметрийн илрүүлэг) | эмчилгээ ихэнх АНЭ-ийн түвшинд нэвтрүүлсэн бусад арга эхлэл байна. | оо эмчилгээний зааврыг ЭМС-ын тушаалаар батлуулсан байна. | үйлчилгээнд нэвтрүүлж, тайлант хугацаанд амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 26 нярайд сурфактант эмчилгээг хийж, 84.6%-ийн үр дүн өгсөн нь өмнөх оны мөн үеэс 13.2%-р нэмэгдсэн.<br>-“Нярайн цогц скрининг шинжилгээг нутагшуулах нь” эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг ЭМЯ, НҮБХС, Нярайн цогц скринингийн үндэсний багтай хамтран зохион байгуулж, Орхон, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв нийт 5 аймгийн 6 эрүүл мэндийн байгууллагын 19 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан. НҮБХС, ЭМЯ-аас 14.5 сая төгрөгийн санхүүжилтээр нярайн эрт илрүүлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг (хөдөлгөөнд тэсвэртэй пульскосиметр 17 ширхэг, арклайт 5 ширхэг) нярайн тасагт хүлээлгэн өгсөн.<br>- 2025 оны 10-р сараас эхлэн нярайн пульсоксиметрийн скринингийг БОЭТ-ийн нярайн тасагт нутагшуулан зүрхний төрөлхийн гажгийг эрт илрүүлэх скринингэд төрсөн 332 нярай хамрагдаж, зүрхний эмгэг илрээгүй байна. | |
| 2.21 | Гамшиг, онцгой байдал /зуд, үер, халдварт өвчин/ нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед үүссэн эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн бүх төрлийн нөөцийг бүрдүүлэх, төлөвлөх хариу арга хэмжээний төлөвлөлтийг урьдчилан хийж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах. | Төлөвлөгөө боловсруулсан байна. | Төлөвлөгөө батлагдсан байна. Нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт шинэчлэгдсэн байна. | Эрүүл мэндийн газар нь Тохиолдол удирдлагын тогтолцоонд шилжин нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдал, тусламж үйлчилгээний чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 4 удаагийн дэмжлэгт хяналт хийж, хяналтын зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эх барихын тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор төрөх өрөө, эрчимт эмчилгээний өрөөний амиллуулах болон лавшруулсан тусламж үзүүлэхэд хүүхдэд хэрэглэгдэх тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслийг Аймгийн онцгой комиссын хуралдаанаар шийдвэрлүүлэн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган чадавхыг нэмэгдүүлсэн.<br>Эх барих болон хүүхдийн тусламжийн нарийн мэргэжлийн баг бүрдүүлж, үйл явдлын үед ажиллах нэмэлт ээлж, багийн зохион байгуулалтаар хуваарилалт хийж, томуу томуу төст өвчний дэгдэлтийн үед ажиллах 14 хүүхэд, нярайн их эмч 16 хүүхэд нярайн сувилагчийн судалгааг ЭМХТ-д хүргүүлэн, болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дайчлагдан ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааг шинэчилсэн.<br>Томуу,томуу төст өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хурлыг 8 удаа зохион байгуулж,шийдвэрийн хэрэгжилтийг 95,6% ханган ажилласан. Эрсдэлт бүлгийн хүн ам /0-5 насны хүүхэд, жирэмсэн төрсөн эх, хэвтрийн, 4,5 бүлгийн архаг өвчтэй иргэд/-ын судалгааг шинэчлэн, эрсдэлийн үеийн харилцаа холбоог идэвхжүүлэн тусламж үйлчилгээг гэрийн эргэлтэд бүрэн шилжүүлж ажилласнаар | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | эндэгдэл багатай даван туулсан байна.<br>Тайлант хугацаанд анхан шатны байгууллагын болон боловсролын байгууллагын эмч нарыг чадавхжуулах 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 126 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан байна. | |
| 2.22 | Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийн тохиолдлыг бүртгэж, мэдээлэхэд ДЭМБ-ын шинэчлэгдсэн удирдамж, зааврын дагуу эхийн болон перинатал эндэгдлийн тандалт хариу арга хэмжээг эрчимжүүлэх. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/550 тоот тушаал | Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээний баг байгуулж, ЭМС-ын 550, 263 тушаалыг шинэчилсэн байна. | Тайлант хугацаанд тав хүртэлх насны хүүхдийн 13 эндэгдэл, эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдлыг бүртгэж мэдээлсэн бөгөөд цаашид эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийн тохиолдлыг бүртгэж, мэдээлэхэд шинэчлэгдэн батлагдсан ЭМС-ын 2025 оны А/419, А/420 дугаар тушаалын дагуу Магадлан хэлэлцэх зөвлөлийн хурлын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, мэдээллийн урсгалыг ЭМБ-уудад танилцуулан сурталчилсан.<br>ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанаас зохион байгуулсан ЭМС-ын 2025 оны А/419, А/420 дугаар тушаалыг танилцуулах, чадвахжуулах сургалтад Орхон аймгийн БОЭТ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч, нярайн тасгийн эмч, эрчимт эмчилгээний эмч зэрэг 15 хүн 3 өдрийн сургалтад хамрагдан чадавхжсан байна. | 70 |
| 2.25 | Эх баригчийг хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах. | | Арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. | Өрхийн эрүүл мэндийн төвийн 8 эх баригчийг ажлын 5 өдөр БОЭТ-ийн өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн кабинетад сэлгэн ажиллуулж ажлын байран дээр дадлагажуулан чадавхжуулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх тасгийн 22 сувилагчийг Эх нярайн үндэсний төв II-ийн төрөх тасагт ажлын 2 хоног туршлага судлуулан дадлагажуулсан байна.<br>АШУҮИС-ын Дархан-Уул аймгийн салбарын сувилахуйн сургуультай хамтран зохион байгуулсан жирэмсний хяналт, гэр бүл төлөвлөлт, эх барихын яаралтай тусламжийн 4 төрлийн чиглэлээр онол, дадлагат сургалтад сум, өрх, БОЭТ-ийн 30 эх баригчийг хамруулсан чадавхжуулсан байна. | 100 |
| 2.29 | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудад жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэгслийн сонголт хийх | Анхан шатны ЭМБ-уудад ЖХАХ-ийн нөөц байна. | ЖХАХ-ийн нөөц бүрдүүлсэн байна. | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж буй нийт 16,297 эмэгтэй (65.1%) байгаа нь оны өмнөх үеэс 419 тохиолдлоор нэмэгдсэн байна. Тайлант онд 1295 эмэгтэй жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслээ зогсоож, 1714 эмэгтэй шинээр жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж байна. Жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн төрлөөр авч үзвэл хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн 2901 буюу 17.8% нь жирэмслэлтээс хамгаалах эм, 1535 | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | боломж бүрдсэн, жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн орчин үеийн арга, хэрэгслийн тав ба түүнээс дээш сонголттой, гурваас доошгүй сарын нөөцтэй болсон байна. | | | буюу 9.4% нь тариа, 797 буюу 4.9% нь суулгац, 4603 буюу 28.2% нь бэлгэвч, 4921 буюу 30.2% нь ерөндөг, 372 буюу 2.3% нь гуурсан хоолой боох ажилбар, 1168 буюу 7.2% нь бусад төрлийн арга хэмжээ ашиглаж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн 1 сарын нөөцтэй байна. | |
| 2.30 | Амаржих газар төрөх тасаг, төрсний дараах тасагт эхэд туслах туслагч, гэр бүлийн гишүүн, "ДОУЛА" хамт байлгахыг дэмжих, тэдэнд таатай орчин бүрдүүлэх. | | Жирэмсэн эмэгтэй, төрсөн эхийг хүссэн тохиолдолд туслагчийг хамт байлцуулах ажлыг эхлүүлсэн байна. | Тайлант хугацаанд Орхон аймгийн БОЭТ-ийн төрөх тасагт 1761 эх төрсөн байна. Төрсөн эмэгтэйчүүдийн дунд хийсэн судалгаагаар төрөх тасагт төрлөгийн явцад хамтрагчаа сонгож, хамт байсан эхчүүдийн хувь - 26.3%, төрөх үед туслагч сонгож хамт байсан эхчүүдийн хувь - 24.1% байна. Төрөх тасагт хамтрагчтай байрлаж болох 2 өрөөтэй, хүндрэлтэй болон бусад ээжүүд шаардлагатай үед хамтрагчийн хамт эмнэлэгт тусламж үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн байна. Мөн 2026 онд орон нутгийн 2.2 тэрбумын хөрөнгө оруулалтаар төрөх тасгийн дотор засвар, сангийн ажил хийгдэж, төрөх болон төрсний дараах тасгийн эх, хүүхдэд ээлтэй, тав тухтай орчинг бүрдүүлсэн байна. | 100 |
| **3** | **Зорилт 3. Бага насны хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нотолгоонд тулгуурласан үр дүнтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, дэлхийн хөгжингүй улс орнуудад нэвтрүүлж буй шинэ арга технологийг нутагшуулах, хүүхдийн хоол тэжээл, хөгжлийг дэмжих, тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, төвлөрлийг сааруулж, хүртээмжийг нэмэгдүүлэн, чанарыг сайжруулж, хүүхдийн сэргийлж болох өвчлөл эндэгдлийг бууруулах.** | | | | |
| 3.1 | Тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийг хянах чадварыг эцэг, эх асран хамгаалагчдад эзэмшүүлж, эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр-ийг бүрэн хөтөлж хэвшүүлэх | - | Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн цахим маягт боловсруулсан байна. | -Тайлант хугацаанд товлолын дархлаажуулалтад хамрагдвал зохих 5973 хүүхдээс 5967 хүүхэд хамрагдаж, бүрэн тунгийн хамралт 99,8% буюу өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Улаанбурханы нөхөн дархлаажуулалтад 745 хүүхдийн хамруулж, 1774 хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд нөхөж оруулан, нөхөн дархлаажуулалтад хамрагдвал зохих 3717 хүүхдээс 2519 хүүхэд нөхөн дархлаажуулалт болон цахимд нөхөн бүртгэж, хамралт 70% буюу 38% тус тус нэмэгдсэн байна.<br>- Эх, нярайн тусламж үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд нярайн эрүүл, эмгэгийн зааг, нярайн шарлалтын оношилгоо, эмчилгээний менежмент, эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлтөд анхаарах асуудлууд сургалтад анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 24 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж, эцэг, эх, асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл өгөх, ур чадварыг нэмэгдүүлсэн.<br>- Бага насны хүүхдийн өсөлт, хөгжлийг хянах, эх, хүүхдийн эрүүл мэндийн | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дэвтрийн хөтлөлтийг сайжруулах чиглэлээр сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 27 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хүүхдийн өсөлт хөгжлийг хянах чадавхыг сайжруулсан.<br>- СӨЭМТ-үүдэд 0-1 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтад хамрагдалт 94,3% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар нэмэгдсэн байна. | |
| 3.3 | Нялхас бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих богино хугацааны сургалтын хөтөлбөрийг боловсруулан хөтөлбөрийн дагуу сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах | - | Сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулсан байна. | Тайлант хугацаанд Тогтвортой хөгжил ТББ-тай хамтран эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн Эрүүл эхээс - Эрүүл хүүхэд" уриатай “Амьдралын алтан 1000 хоног" сургалтыг зохион байгуулж, “Нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө"-г орон нутагт бэлтгэгдсэн сургагч багш нарын оролцоотой эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг 8 удаа зохион байгуулж 390 жирэмсэн эх, түүний гэр бүлийг хамруулж 2 төрлийн 395 ширхэг гарын авлагыг түгээж ажилласан. Тус сургалтаар “Амьдралын эхний 1000 хоног”-ийн хугацаанд хүүхдийн өсөлт, хөгжлийг дэмжих, хянах, эх хүүхдийн эрүүл мэнд, нялхас бага насны хүүхдийн хоол тэжээл, асаргааны талаар эцэг, эх асран хамгаалагчдын эрүүл мэндийн боловсрол дээшилсэн.<br>-“Амьдралын алтан 1000 хоног" өдөрлөгт хүүхдийн нэмэгдэл хоолны жороор мэргэжлийн тогоочийн бэлтгэсэн зутан шөл болон буузаар сургалтад оролцогчдод үйлчилж, хүүхдийн нэмэгдэл хоолны жортой картыг өдөрлөгт оролцсон 150 гаруй иргэдэд түгээж ажилласан.<br>- Өрхийн эрүүл мэндийн төвүүд “Ээжүүдийн клуб”-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, 6-10 төрлийн сэдвийн хүрээнд 31 удаагийн сургалтад давхардсан тоогоор 979 жирэмсэн болон хөхүүл эхчүүд, бага насны хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулан эрүүл мэндийн боловсрол олгож эх, хүүхдийн эрүүл мэнд, асаргаа, хоол тэжээл, хөх арчилгаа, жирэмсний хяналтын ач холбогдлын талаар эрүүл мэндийн боловсрол олгож, тэдний мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн.<br>- Ээжүүдийн клубын хүрээнд бага насны хүүхдийг нэмэгдэл хоолонд хэрхэн оруулах, насанд нь тохирсон хооллолтын зөвлөгөөний 4 төрлийн рийл бичлэг хийж цахим хаягт байршуулж давхардсан тоогоор 1363 иргэнд түгээсэн.<br>- “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхам”-ын сургалтыг зохион байгуулж, БОЭТ-ийн төрөх, хүүхэд, нярайн тасгийн эмч, сувилагч, сум өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан. | 100 |
| 3.5 | Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, хөгжлийг дэмжих | - | Хэрэгцээг тогтоосон байна. | - БОЭТ-ийн Хүүхдийн тасагт 8 эмч, 17 сувилагч ажиллаж байгаа ба Нярайн тасагт 6 нярайн эмч, 11 сувилагч ажиллаж, нярай, хүүхдийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна. Орхон аймгийн хэмжээнд хүүхдийн | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | чиглэлд нэн шаардлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг (хэл засалч, хөдөлгөөн засалч, нярайн эмч сувилагч, хүүхдийн мэс засалч хоол зүйч..) хүүхдийн өвчин эмгэгийн хөдлөлзүйд тулгуурлан гадаад, дотоод сургалтуудад хамруулан бэлтгэж, ажиллуулах | | | мэдрэл, зүрх судас, дотоод шүүрэл, бөөр, арьс харшил, гастроэнтерологи, эрчимт эмчилгээ, хүүхдийн мэс заслын эмч нар ажиллаж байна. Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, хөгжлийг дэмжих чиглэлээр хөдөлгөөн засалч-4, хэл засалч-1 эмч тусламж үйлчилгээ үзүүлж байна.<br>Тайлант хугацаанд БОЭТ-ийн нярайн тасгийн эрхлэгч Узбекстан улсын Ташкент хотноо "Нярай, перинаталь эмнэлзүйн форум"-д, хүүхдийн тасгийн эрхлэгч Солонгос улсын Сөүл хотноо "Олон улсын мэдрэлийн эмч нарын конгресс"-т тус, тус оролцож, туршлага солилцож, хамтын ажиллагаа уялдаа холбоог нэмэгдүүлсэн.<br>- 2025 онд улсын төсвийн санхүүжилтээр 2 эмч хүүхэд судлалын үндсэн мэргэшлээр суралцаж байна.<br>- БОЭТ, ЭХЭМҮТ-тэй хамтран нярайн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд чадавхжуулах, сэлгэн ажиллуулах хүрээнд БОЭТ-ийн нярайн тасгийн 4 эмч тус бүр 7 хоногоор, 4 сувилагчийг ажлын 2 өдрөөр ЭХЭМҮТ-ийн дутуу нярайн тасаг, эрчимт эмчилгээний тасагт дадлагажуулан дутуу болон хэт бага жинтэй нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор туршлага судлуулан чадавхжуулсан. | |
| 3.6 | ЭМАШТҮ үзүүлэгчдийг хүүхдийг хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, зөвлөгөө өгөх ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургаж бэлтгэх | - | Сургалтын хөтөлбөрийг боловсруулна. | - Хүүхдийн тусламж, үйлчилгээнд бага насны хүүхдийн хөгжлийг хянах, өсөлт, хөгжлийн хоцролтыг эрт илрүүлэх 9,18,36 сартай хүүхдийн цогц үзлэгийг тогтмол, тасралтгүй зохион байгуулж байна. 9,18,36 сартай хүүхдийн цогц үзлэгт 2284 хүүхдийг хамруулснаас 79 хүүхдэд хөгжлийн хоцрогдлыг илрүүлж лавлагаа шатлалд илгээж, хяналтад авсан байна.<br>- "Хүүхдийн өвчний шинэчилсэн цогц менежмент", эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, бага насны хүүхдийн өсөлтийг үнэлэх, хянах мэдлэг сэргээх, эмнэлзүйн удирдамжийн сургалтыг 4 удаа давхардсан тоогоор 125 анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулж, нялхас, бага насны хүүхдийн хооллолт, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх чиглэлээр чадавхжуулсан.<br>-"Нярайн цогц скрининг шинжилгээг нутагшуулах нь" нярайн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг ЭМЯ, НҮБХС-тай хамтран зохион байгуулж, Орхон, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв нийт 5 аймгийн 6 эрүүл мэндийн байгууллагын 19 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан. | 100 |
| 3.7 | ХӨЦМ-ийн хэрэгжилтийг идэвхжүүлж бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаатай уялдуулан, холбогдох арга | - | Сургалтын хөтөлбөрийг нягтлан шинэчлэн боловсру | - Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээ, томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээ, хүүхдийн хүлээн авахаас үзүүлээд буцсан, хэвтээд гарсан хүүхдийн бүртгэл судалгаа, гэрийн эргэлт, хүүхдэд үзүүлж буй тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь эрүүл болон өвчтэй хүүхдийн үзлэг, өсөлт хөгжлийг үнэлэх өрөө, | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэмжээ авч хэрэгжүүлэх | | улсан байна. | дархлаажуулалтын өрөө, ХӨЦМ-ийн чиглэлээр шингэн сэлбэх, утлага хийх цэг, хүүхэд хөхүүлэх хэсэг, эх хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох өрөөнүүдийг эх хүүхдэд ээлтэй байдлаар тохижуулан тусламж үйлчилгээ авах мэдээллийн урсгалыг олон нийтэд ил тод байршуулаад байна.<br>- СӨЭМТ-үүдэд 0-1 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтад хамрагдалт 94,3% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар нэмэгдсэн байна.<br>- Монголын Хүүхдийн Анагаахын академи, АШУҮИС-ийн АУС-ийн Хүүхдийн анагаахын тэнхимтэй хамтран "Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгүүд" "Хүүхдийн мэдрэл сэтгэцийн эмгэгүүд", "Хүүхдийн өвчний шинэчилсэн цогц менежмент" сэдэвт сургалтыг зохион байгуулж сум, өрхийн эрүүл мэндийн төв, БОЭТ, хүүхдийн клиникийн 44 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан. | |
| 3.10 | Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн сайжруулах “Эрүүл шүд” хөтөлбөрийг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, бусад салбарын оролцоотойгоор хэрэгжүүлэх, цахим бүртгэл мэдээллийн системтэй болгож хяналтыг сайжруулах | - | | Сургуульд суурилсан илрүүлэгт 22 сургуулийн 2576 суралцагчаас 2557 (99.2%) хамрагдсан. Илрүүлэгт 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) нь эмчлэн эрүүлжсэн.<br>Шүдний илрүүлэгт 2276 хүүхэд хамрагдахаас 95,1% нь хамрагдсан. Үзлэгээр 2405 /99%/ хүүхэд фторт түрхлэг түрхүүлсэн, шүдний цооролтой 2018 /88,6%/, шүдний гажигтай 681 /27,7%/, шүдээ бүрэн угаадаггүй 1998 /81.5%/, шүдний эмчилгээнд хамрагдсан 1783 хүүхэд байна. Aimag.Eruulhuuhed.mn цахим системд 19 эрүүл мэндийн байгууллага, 22 ерөнхий боловсролын сургуульд цахим хаягийн эрхийг нээн, сургуульд суурилсан эрт илрүүлгийн нүд, шүд, зүрхний үзлэгийг тус программд бүртгэн оруулсан.<br>Амны хөндийн эрүүл мэндийг сахих, зөв дадлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсролын байгууллагын 56 нэгжид зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулиудад 7 хоногт 1 удаа ангидаа шүд угаах аяныг өрнүүлж 24 сургуулийн 25122 хүүхдийг хамруулсан байна.<br>Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” шүд, гараа зөв угааж сурах аяныг өрнүүлж, Шүдний олимпиадыг улсын хэмжээнд анх удаа Шүдний холбоотой хамтран орон нутагт зохион байгуулж, нийт 630 хүнийг хамруулсан.<br>- Алслагдсан сум Жаргалант сумын эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн яамнаас Эрүүл шүд арга хэмжээний хүрээнд 51,0 сая төгрөгийн санхүүжилт бүхий шүдний кабинет байгуулагдсан бөгөөд Хаш шүдний эмнэлэгтэй гэрээ хийж, хамтран ажиллаж, Жаргалантын 3-р сургуулийн 1 дүгээр ангийн 35 хүүхдийг шүдний үзлэг, фторт түрхлэгт хамруулсан байна. | 100 |
| 3.12 | Хүүхдэд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, | - | Хүүхдэд яаралтай | - Бага насны хүүхдийг ахуйн болон гэнэтийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр хүүхдийн байгууллагын эмч нарыг чадавхжуулах сургалтыг зохион | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | эрэмбэлэн ангилалтыг эрчимжүүлж өрх сум, түргэн тусламж, эмнэлгийн мэргэжилтнүүдийг нэн тэргүүнд сургаж дадлагажуулах | | тусламж, эрэмбэлэн ангилалтын чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийг сургах, давтан сургах үйл ажиллагаа эхлүүлэх | байгуулсан ба ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 50 эмчийг хамруулсан.<br>- ЕБС, СӨБ-ын эмч нарыг яаралтай тусламжийн чиглэлээр чадавхжуулах "Хүүхдэд үзүүлэх амилуулах суурь тусламж", "Хахалтын үеийн тусламж үйлчилгээ", "Амилуулах суурь тусламж" сэдэвт сургалтыг зохион байгуулж 31 эмч нарыг хамруулан чадавхжуулсан.<br>- ЭХЭМҮТ-өөс зохион байгуулсан “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж” сэдэвт цахим сургалтад хүүхдийн эмч, СӨЭМТ-ийн 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>- Анхан болон лавлагаа шатлалын 24 байгууллагын үйлчлүүлэгчийг танин тодруулах, эрэмбэлэн ангилах, амилуулах яаралтай тусламжийн чиглэлээр эмнэлзүйн 5 удирдамжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, дунджаар 81,5%-тай дүгнэгдсэн.<br>- Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэг,УНТЭ-тэй хамтран Монгол улсын зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор Бямбаагийн Батбаяр агсны нэрэмжит“Миний мэргэжил–Миний бахархал”сэдэвт яаралтай амилуулах суурь тусламжийн ажил мэргэжлийн уралдаанд Эрдэнэт медикал, ХХЭМБ, Мөнхсүндрэл ӨЭМТ, Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн "AVENGERS" нэгдсэн баг шилдгээр шалгарч,эмч,эмнэлгийн мэргэжилтэн, жолооч нийт 11 хүн 4,0 сая төгрөгийн шагнал, өргөмжлөлөөр шагнагдсан. | |
| 3.14 | Сэргийлэх боломжтой өвчин эмгэгээс шалтгаалсан нас баралтыг бууруулахын тулд хүүхдийн осол гэмтэл, уушгины хатгалгаа, нярайн үжил халдвараас сэргийлэх чиглэлээрх оношилгоо, эмчилгээний заавры г нягтлан, эмч мэргэжилтнийг сургах, товлолын дархлаажуулалтын бүрэн хамралтыг нэмэгдүүлэх | - | Хүүхдийн уушгины хатгалгаа, нярайн үжлээс сэргийлэх зааврыг ДЭМБ болон ОУБ-аас өгч буй зөвлөмжийн дагуу шинэчлэн боловсруулж ЭМС-ын тушаалаар | - Тайлант хугацаанд ЭМГ-аас томуу, томуу төст өвчлөл, хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх, нярайн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр танхимын 3 удаагийн сургалт, ажлын байран дээрх 1 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 152 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, чадавхжуулсан.<br>- Томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хурлыг 8 удаа хийж, 17 асуудал хэлэлцэж, 14 шийдвэр гарган,хэрэгжилтийг 95,6%-тай ханган ажилласан.<br>-Тайлант хугацаанд Товлолын дархлаажуулалтад хамрагдвал зохих 5973 хүүхдээс 5967 хүүхэд хамрагдаж, бүрэн тунгийн хамралт 99,8% буюу өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, халдварт өвчний хариу арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр засаг даргын захирамжаар 2 ажлын хэсэг байгуулж, 23,7 сая төгрөгийг шийдвэрлэн, хэрэгжилтийг 100% хангаж ажиллалаа.<br>- Аймгийн хэмжээнд “Агшин бүрт анхаарал сэрэмжийг нэмж-эрсдлийг бууруулъя” уриатай иргэдэд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөмжийг цаг алдалгүй хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор 5 төрлийн үйл ажиллагааг төлөвлөн 95 хувьтай хэрэгжсэн байна.<br>- Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт медикал, Улаан загалмайн | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | батлуулсан байна. | хороотой хамтран анхан шатны эрүүл мэндийн байгууллага, хүүхдийн 45 байгууллагын 58 эмч, эмнэлгийн ажилтнуудад осол гэмтлийг бууруулах, арга хэмжээ авах чиглэлээр 6 сэдвээр сургалтад хамруулан чадавхжуулсан. Эдгээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд харьяаллын дагуу 15 сургуулийн 2412 хүүхдэд осол гэмтлээс сэргийлэх сургалт нөлөөллийг ажлаар эрүүл мэндийн боловсрол олгож, 5 төрлийн гарын авлага түгээн ажилласан.<br>- ЭМГ-ын цахим хуудсаар хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр 7 зурган постер, 6 видео шторк нийт 13 мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд байршуулан сурталчилсан бөгөөд 23651 хүн үзсэн байна. | |
| 3.16 | Хүүхдийн анагаахын чиглэлээр ЭМАШТҮ үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг хүүхдийн анагаахын суурь мэдлэг, эзэмшүүлж мэргэшүүлэх богино хугацааны сургалтад тасралтгүй хамруулж бэлтгэх | | Сургалтын хэрэгцээг тогтоосон байна. | Хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээний чиглэлээр танхимын 11 сургалтад 354, ЭХЭМҮТ-ээс зохион байгуулсан 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн өнөөгийн байдал, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах 6 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 63 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>- Бага насны хүүхдийг ахуйн болон гэнэтийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх, өсвөр үеийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох сургалтад хүүхдийн байгууллагын 50 эмчийг хамруулсан.<br>- Анхан шатны тусламж үйлчилгээнд өсвөр үеийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгын хүрээнд 7 СӨЭМТ-үүдийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байранд чадавхжуулах сургалтад хамруулан арга зүйн зөвлөмж өгсөн.<br>-Цаг үеийн нөхцөл байдал, тав хүртэлх насны хүүхдийн өвчлөл, эндэгдэл, 2024 оны магадлан хэлэлцэх зөвлөлийн зөвлөмж, нярайн эндэгдлийг бууруулах төлөвлөгөөг танилцуулах сургалтыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 29 эмчид зохион байгуулсан.<br>-Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Өсвөр үеийн эрүүл мэнд хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох, чадавхжуулах сургалтыг сум, өрхийн эмч, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудын 51 төлөөллийг хамруулан зохион байгуулсан.<br>-ЭМС-ын А/ 292 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд жирэмсний хяналтыг сайжруулах чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг БОЭТ-ийн төрөх тасагтай хамтран зохион зохион байгуулж, сум, 8 ӨЭМТөвийн 24 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан.<br>-"Нярайн цогц скрининг шинжилгээг нутагшуулах нь" нярайн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг ЭМЯ, НҮБХС-тай хамтран зохион байгуулж, Орхон, Булган, Сэлэнгэ, дархан-Уул, Төв нийт 5 аймгийн 6 эрүүл мэндийн байгууллагын 19 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хамруулж чадавхжуулсан<br>- “Хүүхдийн өвчний шинэчилсэн цогц менежмент", эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, бага насны хүүхдийн өсөлтийг үнэлэх, хянах мэдлэг сэргээх, эмнэлзүйн удирдамжийн сургалтыг 4 удаа давхардсан тоогоор 125 анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулж, нялхас, бага насны хүүхдийн хооллолт, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх чиглэлээр чадавхжуулсан. | |
| 3.17 | Бага насны хүүхдийн хамгааллыг сайжруулах, ээж, асран хамгаалагчдын мэдлэгийг дээшлүүлж, ахуйн осол гэмтлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг засаг захиргааны анхан шатны нэгж байгууллага, боловсрол, хүүхэд хамгаалал, хэвлэл мэдээлийн байгууллага, албан тушаалтнуудтай хамтран хэрэгжүүлэх | | Үйл ажиллагааны төлөвлөгөөг орон нутгийн ЭМГ бүр боловсруулж батлан, хэрэгжүүлж эхэлнэ. | Тайлант хугацаанд хүүхэд хамгааллын тухай хууль болон эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын чиглэлээр эрх зүйн баримт бичгүүдийн талаар 2 удаагийн чиглэл, мэдээлэл сургалтыг зохион байгуулж 95 сум, өрхийн эрүүл мэндийн төв эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтныг хамруулж чадавхжуулан арга зүйгээр хангаж ажилласан.<br>- Орхон аймгийн хүүхдийн төлөө зөвлөлөөс 2025 оны 6 дугаар сард сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын амралт эхэлсэнтэй холбоотойгоор 2-6 насны хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчид ажлын байдлаас шалтгаалан гэртээ харгалзах хүнгүй үлдээх, осол гэмтэлд өртөх эрсдэлтэй тул 0-5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх саран хамгаалагчдын ажлын цагт уян хатан зохицуулалт хийх тухай Засаг даргын чиглэлийг байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.<br>- Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр БГ, ХГБХГ, ЦГ-тай хамтран “Өсвөр үеийнхнийг ойлгоё, сонсъё” аяныг зохион байгуулж, 6 төрлийн үйл ажиллагаа, 69 удаагийн сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэг, 16 удаагийн өдөрлөгт 19 сургуулийн 5-12 дугаар ангийн 3013 хүүхдэд зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөмж бүхий 2-5 төрлийн 3155 гарын авлагыг түгээж ЭМБ-ыг олон талт байдлаар олгож, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж ажилласан.<br>- Ахуйн орчин дахь осол гэмтэлд өрөх эрсдлийг үнэлэх үнэлгээний орон сууцны судалгааг 65 өрх, гэр хашаанд амьдардаг 25 өрх, байшин хашааны судалгааг 30 өрх буюу нийт 120 өрхийг судалгаанд хамруулан ажилласан. Судалгаагаар орон сууцны 26 өрх, гэр хашааны 13 өрх, байшин хашааны 18 өрх эрсдэлтэй гэж дүгнэгдсэн бөгөөд 14 хоногийн дараа Судалгааг хийх явцад орон сууцны 14, гэр хашааны 7, байшин хашааны 9 өрхийн эрсдлийг бууруулж ажилласан. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх туйхай 4 төрлийн 480 ширхэг гарын авлагыг түгээсэн.<br>- Дархлаажуулалтын талаар иргэдэд мэдээлэл түгээх 4 удаагийн аян, 2 өдөрлөг зохион байгуулж, 1 төсөл хэрэгжүүлэн ажилласан. Дээрх арга хэмжээнд 70 гаруй байгууллага хамтран ажиллаж, давхардсан тоогоор 7000 гуруй сурагч, 6000 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөлөл | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хамрагдсан. | |
| 4 | **Зорилт 4. Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тогтвортой үргэлжлүүлэн, чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхэд өсвөр үеийнхний хөгжлийг дэмжих.** | | | | |
| 4.1 | Өсвөр үеийн эмч, эмнэлгийн сэтгэлзүйчийг сургаж бэлтгэн , өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг тогтвортой, чанартай үзүүлэх | Өсвөр үеийн эмч- 21 аймаг, 8 дүүрэг | Өсвөр үеийн эмч, эмнэлгийн сэтгэлзүйчийг бүх аймаг, дүүрэгт бэлтгэж эхэлнэ. | Өсвөр үеийн кабинет нь Эрүүл мэндийг дэмжих төвд багаж тоног төхөөрөмжөөр 88%-тай хангагдан тусламж үйлчилгээ үзүүлж ирсэн ба хүний нөөцийн дутагдалтай байна. Тайлант хугацаанд өсвөр үе, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чиглэлээр 3 албан тоот, 3 мэдээлэл, 2 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгсөн.<br>- ЭМС-ын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/504 дугаар тушаалаар батлагдсан өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний журмыг 7 СӨЭМТ-ийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд танилцуулан ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж арга зүйн зөвлөмж өгч чадавхжуулсан.<br>-ЭМГ-аас хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 354 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, дунд ангийн 70 багшийг хамруулж чадавхжуулсан.<br>-Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх аяны хүрээнд ЭМ-ийн олон талт боловсрол олгох сургалтыг 1-12 дугаар ангийн 150 хүүхдэд зохион байгуулж, хүүхдийн аюулгүй тусламжийг дэмжих, аюулгүй байдлыг хангах постер мэдээлэл зөвлөмжийг 17 сургуулийн 586 сурган хүмүүжүүлэгч, 2909 сурагч, эцэг, эх асран хамгаалагчдад түгээсэн.<br>-Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр БГ, ХГБХГ, ЦГ-тай хамтран “Өсвөр үеийнхнийг ойлгоё, сонсъё” аяныг зохион байгуулж, 6 төрлийн үйл ажиллагаа, 69 удаагийн сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэг, 16 удаагийн өдөрлөгт 19 сургуулийн 5-12 дугаар ангийн 3013 хүүхдэд зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөмж бүхий 2-5 төрлийн 3155 гарын авлагыг түгээж ЭМБ-ыг олон талт байдлаар олгож, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж ажилласан.<br>-Өсвөр насны охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг зохион байгуулж, 552 охидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан 33 хүүхдийг эмчийн хяналтад авсан.<br>ЭМГ-ын цахим хуудсаар хүүхэд, өсвөр үеийн чиглэлээр 41 постер, 10 видео шторк нийт 51 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 126762 иргэнд түгээсэн. | 70 |
| 4.2 | Өсвөр үеийнхэнтэй ярилцах, зөвлөгөө өгөх ур, чадварт өрх, сум багийн эмч, эх баригч, нийгмийн | | Сургалтын хөтөлбөр боловсру | Тайлант хугацаанд өсвөр үеийнхний эрүүл мэндийн чиглэлээр 5 удаагийн сургалтаар нийт 245 сум, өрхийн эмч, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудыг хамруулж чадавхжуулсан. Үүнд:<br>- ЭМС-ын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/504 дугаар | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ажилтан, сургуулийн эмч нарыг сургаж бэлтгэх | | улсан байна. | тушаалаар батлагдсан өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний журмыг 7 СӨЭМТ-ийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд танилцуулан ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж арга зүйн зөвлөмж өгч чадавхжуулсан.<br>- Өсвөр үеийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгож хүүхдийн байгууллагын эмч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан ба ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 50 эмчийг хамруулж тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн.<br>- Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Өсвөр үеийн эрүүл мэнд хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох, чадавхжуулах сургалтыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудын 51 төлөөллийг хамруулан зохион байгуулсан.<br>-БГ-тай хамтран өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, анхаарах асуудлуудын талаар 2 удаагийн сургалтыг ЕБ-ын 24 сургуулийн дунд ангийн 70 багшид зохион байгуулж тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн.<br>- Өсвөр насны охидын төрөлт, жирэмслэлт, үр хөндөлтийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудлуудын талаар мэдээлэл олгох сургалтыг боловсролын 18 байгууллагын 18 эмчид зохион байгуулж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан. | |
| 4.3 | Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн (зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх үе тэнгийн дээрэлхэлтийг арилгах, зөв зангийн үйлийг төлөвшүүлэх, аливаа хэлбэрийн хорт зуршил, донтолт, БЗДХ, хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх) чиглэлээрх мэдээлэл сурталчилгааг түгээх, үе тэнгийн зөвлөгч бэлтгэх | | | Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр БГ, ХГБХГ, ЦГ-тай хамтран "Өсвөр үеийнхнийг ойлгоё, сонсъё" аяныг зохион байгуулж, 6 төрлийн үйл ажиллагаа, 69 удаагийн сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэг, 16 удаагийн өдөрлөгт 19 сургуулийн 5-12 дугаар ангийн 3013 хүүхдэд зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөмж бүхий 2-5 төрлийн 3155 гарын авлагыг түгээж ЭМБ-ыг олон талт байдлаар олгож, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж ажилласан.<br>Өсвөр үеийнхэнд "Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн" чиглэлээр үе тэнгийн зөвлөгч бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 21 сургуулийн идэвхтэн 25 хүүхдийг бэлтгэсэн.<br>"Өсвөр насны охид хөвгүүдийн нөхөн үржихүйн онцлог, эрүүл ахуй, хорт зуршил ба эрүүл мэнд сэдвүүдийн хүрээнд СӨЭМТ-ийн харьяа ЕБ-ын 13 сургуулийн 7-12 дугаар ангийн 3369 хүүхдэд 19 удаагийн сургалтаар НҮЭМБ олгож, 2322 гарын авлага түгээж, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн.<br>Тамхины хор нөлөөний талаар 35 удаагийн сургалтад 20 сургууль болон Орхон МСҮТ-ийн оюутан, сурагчид, иргэд 10100 хүн хамрагдаж, 16 төрлийн 2408 тараах материал тараасан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ЭМГ-ын цахим хуудсаар хүүхэд, өсвөр үеийн чиглэлээр 41 постер, 10 видео шторк нийт 51 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 126762 иргэнд түгээсэн. | |
| 4:5 | Сургуульд суурилсан хүүхдийн (6-18 нас) эрт илрүүлгийн хөтөлбөр хэрэгжүүлэх "Сурагчийн эрүүл мэндийн карт" нэгдсэн цахим бүртгэлийн тогтолцоог бий болгох | Нийслэлд-40% сургуульд суурилсан эрт илрүүлэгт хамрагдсан | Нийслэлд -80%-д хүрсэн байна. Орон нутагт эрт илрүүлэг үзлэг эхэлсэн байна. | Сургуульд суурилсан илрүүлэг22 сургуулийн 2576 суралцагчаас 2557 (99.2%) хамрагдсан. Илрүүлэгт 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) нь эмчлэн эрүүлжсэн.<br>● Шүдний илрүүлэгт 2276 хүүхэд хамрагдахаас 95,1% нь хамрагдсан.Үзлэгээр 2405 /99%/ хүүхэд фторт түрхлэг түрхүүлсэн, шүдний цооролтой 2018 /88,6%/, шүдний гажигтай 681 /27,7%/, шүдээ бүрэн угаадаггүй 1998 /81.5%/, шүдний эмчилгээнд хамрагдсан 1783 хүүхэд байна.<br>● Нүдний илрүүлэгт 2576 хүүхэд хамрагдахаас 94,6% нь хамрагдсан. Илрүүлгээр нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай 427 буюу 17.5% нь байна. Холын хараа тэнцээгүй 292 /11.9%/, ойрын хараа тэмцээгүй 100 /4.1%/, стерео хараа тэнцээгүй 244 /10%/ байна.<br>● Зүрхний эмгэг илрүүлэг үзлэгт 2576 хүүхэд хамрагдахаас 92.9%-ыг хамруулж, үүнээс зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлттэй илэрсэн 363/ 15,1%/ хүүхдээс 315 буюу 86,7%-ийг зүрхний эхо оношилгоонд хамруулан 27 хүүхдэд зүрхний эмгэг илэрч, хяналтад авсан байна. | 100 |
| 4.8 | Сурагчдын амны хөндийн эрүүл мэндийг дэмжиж, сургууль дээр шүд угаах орчныг бий болгох, "Сүү" хөтөлбөр хэрэгжүүлэх | | Боловсролын яаманд санал хүргүүлсэн байна. | Аймгийн хүүхдийн байгууллагуудад эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах хэсэгтэй эсэхэд ЭМГ-аас нэг удаа үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн. Үнэлгээний дүнгээр СӨБ-ийн байгууллагын 95.0% нь шаардлага хангасан байна. ЕБС-иудаас шүд угаах орчин бүрдүүлэн, шүд угаах булан байгуулсан нэг сургууль, шүд угаах булангийн бэлтгэл ажлыг хийж эхэлсэн гурван сургууль, шүд угаах цагийг тогтмолжуулан хэрэгжүүлж буй дөрвөн сургууль байна.<br>Орхон аймгийн Ерөнхий боловсролын 22 сургуульд сүү хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд Ивээлт сүү ХХК , Сүү ХХК нийлүүлж байна. | 100 |
| 4.10 | Хүүхдэд зонхилон тохиолдох харшлын шалтгаант өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, оношилгоо эмчилгээний чадавхыг сайжруулах | | Харшлаас сэргийлэх чиглэлээр МСС-ны ажил хийж эхэлнэ. Хүүхдэд зонхилон тохиолдо | Цагаан тоосны дэгдэлтийн бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндийг боловсролыг дээшлүүлэх зорилгоор нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, Жаргалант сум, Баян-Өндөр сумын Говил, Баянцагаан багийн иргэд болон хүүхдүүдийг хамруулж, нийт 1201 иргэнд хүрч ажилласан.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах чиглэлээр "Хүүхдэд зонхилон тохиолдох арьс харшлын өвчлөл" түүнд нөлөөлөх хүчин зүйлс сургалтыг СӨЭМТ-ийн 27 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулж, чадавхжуулсан.<br>Тайлант хугацаанд БОЭТ-ийн хүүхдийн тасагт 2214 хүүхэд хэвтэн эмчлүүлснээс өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгалын замын эмгэг 1873 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | х харшлын оношилгоо, эмчилгээний заавар боловсруулсан байна. | (84.5%), хоол боловсруулах замын эмгэг 200 (9.0 %), арьс, харшлийн шалтгаант эмгэг 51 (2.3%), мэдрэл 47 (2.1%), зүрх судасны эмгэг 15 (0.7%), бусад 15 (0.7%) эзэлж байна. | |
| 4.11 | Стрептококкийн халдвар, зүрх судасны эмгэгийг илрүүлэх оношлох, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх | Эрт илрүүлэг үзлэг шинжилгээ хийгдсэн | Үзлэг оношилгог үргэлжлүүлнэ, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг төлөвлөн хийсэн байна. | “Хэрхийн шалтгаант зүрхний өвчнөөс сэргийлэх, бууруулах төсөл”-ийн хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сангаас 68 сая төгрөгийн санхүүжилтээр 25700 ширхэг стрептококкийн хурдавчилсан оношлуурыг хүлээлгэн өгсөн. 2024-2025 оны хичээлийн жилүүдэд Орхон аймгийн ерөнхий боловсролын сургагчдад **“**Хэрэхийн шалтгаант зүрхний өвчнөөс сэргийлэх, түүнийг бууруулах**”** төслийг хэрэгжүүлэн нийт 24 сургуулийн 1-12 дугаар ангийн 25907 (96.3%) хүүхдийг А бүлгийн стрептококкийн скрининг оношилгоонд хамруулснаас 1223 (4.7%) хүүхдийн түргэвчилсэн тест эерэг гарч хяналтад авсан бөгөөд үүнээс 366 хүүхдэд эмийн эмчилгээ, 11 хүүхдэд бензатин бензилпенциллиныг эмнэлзүйн зааврын дагуу тарьж хяналтад авсан. | 100 |
| 4.12 | Өсвөр үеийн жирэмслэлт, төрөлт, үр хөндөлтийн байдлыг судалж, хариу үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх. | | Судалгаа хийх арга, аргачлалыг боловсруулсан байна. | Тайлант хугацаанд өсвөр насны төрөлтийн 72 тохиолдол бүртгэгдэж, нийт төрөлтийн 4%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 18 тохиолдол буюу 1%-иар нэмэгдсэн байна. Төрсөн охидын харьяаллыг авч үзвэл харьяаллын өсвөр насны жирэмсэн - 57 (79.1%), бусад нь өөр орон нутаг, Улаанбаатарын харьяалалтай хүүхдүүд байна. Тайлант хугацаанд өсвөр насны охидын үр хөндөлт - 29 тохиолдол бүртгэгдэж, нийт хийгдсэн үр хөндөлтийн 10.7%-ийг эзэлж байна. Үүнээс харьяаллын охидын үр хөндөлт - 13 (44.8%), бусад харьяаллын охид - 16 (45.2%) байв. Өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлт, үр хөндөлт нэмэгдсэн, хүн амын дундах бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт нэмэгдсэн зэрэгтэй холбогдуулан анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаар харьяаллын өсвөр насны охид, тавиул, өнчин, зорилтот бүлгийн 1768 охидын судалгааг гаргаж, хувийн хэвшлийн эмнэлэг, төрийн бус байгууллага, ЦГ, ГБХЗГ зэрэгтэй хамтран хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна. | 70 |
| **5** | **Зорилт 5. Эмэгтэйчүүд, хүүхэд, тусгай хэрэгцээтэй зорилтот бүлгийнхний өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж, амьдралын чанарыг сайжруулах.** | | | | |
| 5.1 | Эсэн мэнд амаржихуй, ГБТ, ЖСХ, БЗДХ-аас сэргийлэх | | Үйл ажиллага | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр жирэмсэн эх, иргэд, олон нийтэд чиглэсэн “Амьдралын алтан 1000 хоног” сэдэвт 7 | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | чиглэлээр МСС-г нийтийн зах зээлд гаргах ажлыг засаг захиргааны анхан шатны нэгж, хэвлэл мэдээллийн байгууллага, бусад салбар, иргэдийн оролцоотойгоор хамтран хэрэгжүүлэх. | | аны төлөвлөгөөг орон нутгийн ЭМГ бүр боловсруулж, батлуулан, хэрэгжүүлж эхэлнэ. | удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг 388 жирэмсэн эх, түүний гэр бүлд, төрөх тасгийн 50 ээжид биечлэн сургалт зохион байгуулж, 6 видео 7690 хандалт авсан. 7 удаагийн үйл ажиллагааны 2 өдөрлөгийн төрийн байгууллагын идэр насны залуучууд, эмэгтэйчүүдийг хамруулан зохион байгуулсан. Эрүүл мэндийн газрын фэйж хуудсаар “Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд” 3 постер бэлтгэж 16,196 хандалт авсан байна. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагууд жирэмсний хяналтад орж буй эмэгтэйчүүдэд бүлгийн танхимын сургалт болон цахим группээр мэдээлэл түгээн ажиллаж байна. | |
| 5.5 | Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэгийн эмчийг сургаж бэлтгэн, ДЭМТ, АНЭ-т орон тоогоор ажиллуулах. | | Бэлтгэл ажил хангасан байна. | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх тасагт 12 эх барих эмэгтэйчүүдийн эмч ажиллаж байна. Үүнээс зөвлөх зэрэгтэй - 2, ахлах зэрэгтэй - 2, тэргүүлэх зэрэгтэй - 2 эмч ажиллаж байна. Эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслаар мэргэшсэн эмч - 2, эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, үргүйдэл, хэт авиан оношилгоо чиглэлээр нарийссан 2 эмч ажиллаж байна. | 100 |
| 5.7 | Анхан шатны ЭМБ-ын эмч, мэргэжилтэн нарыг НҮЭМ, ГБТ-ийн чиглэлээр зөвлөгөө өгөх ур чадварт суралцах танхимын болон онлайн богино хугацааны сургалтад хамруулах. | | Сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулсан байна. | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын өрх хариуцсан 42 эмчид мэдлэг, ур чадварын үнэлгээг онол болон өртөөчилсөн байдлаар үнэлэхэд жирэмсний эрсдэлийн үнэлгээний өртөөний дундаж-70.6% (эх барихын гадуур үзлэг-79%, жирэмсэн эхийн аарцгийн хэмжилт -86%, манас таталтын урьдлын оношилгоо, урьдчилан сэргийлэлт-56%, гүний венийн бүлэнт бөглөрлийн эрсдлийн асуумж- 58.8%, жирэмсний яаралтай тусламж, кейс - 77%), зөвлөгөө өгөх өртөөний дундаж-64% (жирэмсний дотор муухайралтын үеийн хооллолт- 65.2%, жирэмсний үеийн цус багадалтын зөвлөгөө- 76.5%, гэр бүл төлөвлөлт, зорилтот бүлгийн эмэгтэйд тохирох арга - 52.7%, хөхөөр хоололт, зөв өмхүүлэх -61.5%, ахуйн осол гэмтлээс сэргийлэх, хүүхдийн хэл яриа хөгжүүлэх зөвлөмж -64.4%) тус тус байв.<br>Үнэлгээнд суурилан 70 ба түүнээс бага үнэлгээтэй жирэмсний эрсдлийн үнэлгээ, жирэмсний манас таталт, зөвлөгөө өгөх өртөөний асуултад тулгуурласан мэдлэг сэргээх, эмнэлзүйн удирдамжийн сургалтыг 16 удаа давхардсан тоогоор 291 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулсан. | 100 |
| 5.8 | Жирэмсэн эмэгтэйн өөрийн хяналтыг сайжруулах (биеийн жингээ хянах, эрүүл, зөв хооллох, цус багадалтын шинжийг таних, аминдэм, эрдсийн бэлдмэлийн заавраар дагуу хэрэглэх), ЭМБ-аас | | Жирэмсэн эмэгтэй, гэр бүл, олон нийтэд чиглэсэн мэдээлэл | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр жирэмсэн эх, иргэд, олон нийтэд чиглэсэн “Амьдралын алтан 1000 хоног” сэдэвт 7 удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг 388 жирэмсэн эх, түүний гэр бүлд, төрөх тасгийн 50 ээжид биечлэн сургалт зохион байгуулж, 6 видео 7690 хандалт авсан. Эрүүл мэндийн газрын фэйж хуудсаар “Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд” 3 постер бэлтгэж 16,196 хандалт авсан байна. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагууд жирэмсний хяналтад орж буй эмэгтэйчүүдэд бүлгийн танхимын сургалт болон цахим | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тусламж хайх чадавхыг бэхжүүлэх, мэдээлэл харилцааг хөгжүүлэх. | | , сурталчилгааны материал боловсруулж, ЭМТ-үүд, нийгмийн сүлжээг ашиглан түгээх. | группээр мэдээлэл түгээн ажиллаж байна. | |
| Хэрэгжилтийн дундаж хувь – 94,6% /Тодорхой үр дүнд хүрсэн/ | | | | | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЭМГ-ЫН ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.ХОНГОРЗУЛ

ЭМГ-ЫН ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Л.ЦЭРЭНЛХАМ

ХЯНАЛТ –ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН П.ХИШГЭЭ

## ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Орхон аймаг 2025.12.05

| № | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024.11/ | Хүрсэн түвшин /2025.11/ | Хүрэх түвшин /2028 он/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| **Үр дүнгийн шалгуур үзүүлэлт** | | | | | |
| 1 | Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд) | 0 | 0 | 19.9 | Эхийн эндэгдэл гараагүй. |
| 2 | Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) | 10.3 | 7.3 | 14.7 | Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх оны мөн үеэс 6 тохиолдол буюу 3 промилиор буурсан байна. |
| 3 | Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) | 9.8 | 6.8 | 8.7 | Нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеэс 6 тохиолдол буюу 3 промиллоор буурсан байна. |
| 4 | Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) | 8.2 | 6.2 | 7.1 | Нярайн эндэгдэл өмнөх оны мөн үеэс 6 тохиолдол буюу 2 промиллоор буурсан байна. |
| 5 | Перинатал эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) | 11.4 | 9.0 | 9.1 | Перинатал эндэгдэл 5 тохиолдол буюу 2.4 промиллоор буурсан байна. |
| 6 | Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын түвшин (100,000 амьд төрөлтөд) | 0 | 113.5 | 16.5 | Төрөлхийн тэмбүүгийн 2 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 2 тохиолдол буюу 113.5 промиллоор нэмэгдсэн. |
| 7 | Тав хүртэлх насны өсөлт хоцролттой хүүхдийн хувь | 0.18 | 0.26 | 8.1 | Тав хүртэлх насны өсөлт хоцролттой хүүхэд 0.26 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 0.08 хувиар нэмэгдсэн байна. |
| 8 | Тав хүртэлх насны хоол тэжээлийн цочмог дуталтай хүүхдийн хувь | 0.05 | 0.15 | 2.0 | Тав хүртэлх насны хоол тэжээлийн цочмог дуталтай хүүхдэд 0.15 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар нэмэгдсэн байна. |
| 9 | Тав хүртэлх насны илүүдэл жинтэй хүүхдийн хувь | 2,0 | 1.8 | 11.8 | 2024-2025 оны хичээлийн жилд тав хүртэлх насны хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгт 1-5 насны 7533 хүүхэд хамрагдсан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | ба үүний 134 (1.8%) хүүхэд нь илүүдэл жинтэй байна. |
| 10 | Таргалалттай нөхөн үржихүйн насны эмэгтэйн хувь | 18.0 | 22.3 | 17.2 | Төвийн бүсийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 22.3 хувь нь таргалалттай байна. |
| 11 | Цус багадалттай 5 хүртэлх насны хүүхдийн хувь | 0,8 | 0,7 | 11.8 | Тайлант хугацаанд 5 хүртэлх насны 74 хүүхдэд цус багадалтыг илрүүлж, хяналтад авсан байна. |
| 12 | Цус багадалттай жирэмсэн эмэгтэйн хувь | 2.1 | 3.0 | 17.2 | Жирэмсний эхний хяналтын үзлэгт хамрагдсан 1453 эмэгтэйн 3% буюу 44 эмэгтэйд цус багадалт илэрч, өмнөх оны мөн үеэс 0.9%-аар нэмэгдсэн байна. |
| 13 | Төмөр дутлын цус багадалттай жирэмсэн эмэгтэйн хувь | - | - | 19.7 | Жирэмсний эхний хяналтын үзлэгт хамрагдсан 1453 эмэгтэйн 3% буюу 44 эмэгтэйд цус багадалт илэрч, өмнөх оны мөн үеэс 0.9%-аар нэмэгдсэн байна. |
| **Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт** | | | | | |
| 1 | Ур чадвартай эмч, мэргэжилтний удирдсан төрөлтийн хувь | 99.8 | 99.8 | 99.9 | Тайлант хугацаанд гэрийн төрөлтийн 2 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. Үүнээс харьяаллын бус (Сэлэнгэ) -1, түр оршин суугч, гэр бүлийн хүчирхийллийн асуумжтай, төрөх дуудлага өгөөгүй 1 тохиолдол байна. |
| 2 | Кесар хагалгааны хувь | 29.7 | 26.8 | 27.8 | Кесар хагалгаагаар төрсөн эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.9%-аар буурсан байна. |
| 3 | Нярайн эрт амлуулалтын хувь | 99.2 | 99.6 | 80.2 | Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд 99.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар нэмэгдсэн байна. |
| 4 | Эхийн сүүгээр дагнан хооллосон 6 хүртэлх сартай хүүхдийн эзлэх хувь | 41,5 | 43.1 | 60.0 | 11 сарын байдлаар 1 хүртэлх насны 1538 хүүхэд идэвхтэй хяналтад хамрагдснаас 663 (43.1%) дан хөхөөр, 33 (2.1%) тэжээвэр, 99 (6.4%) холимог хооллолттой, нэмэлт хооллолтой - 743 (48.3%) байна. |
| 5 | Өндөр тунт А аминдэмд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдийн хувь | 100 | 96.5 | 65.5 | 1 хүртэлх насны хүүхдийн өндөр тунт А аминдэмд хамрагдалт 96.5% байна. |
| 6 | Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь | 0.11 | 0 | 30.0 | Тайлант хугацаанд 5 хүртэлх насны хүүхдэд олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл олгоогүй байна. |
| 7 | Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн жирэмсэн эмэгтэйн хувь | 0 | 65.3 | 50.0 | 2025 оны 10-р сараас эхлэн шинээр жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдэд олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг хангаж, тайлант хугацаанд 938 эмэгтэйд 2 дох сарын хэрэглээг олгосон байна. |
| 8 | Үр хөндөлтийн түвшин (1000 эмэгтэйд) | 106.6 | 155.0 | 13.3 | Үр хөндөлт өмнөх оны мөн үеэс 79 тохиолдлоор буюу 48.4 промиллоор нэмэгдсэн байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Жирэмслэхээс хамгаалах арга хэрэгслийн хангагдаагүй хэрэгцээ, хувиар | 35,2 | 34,9 | 30.0 | Тайлант онд 1295 эмэгтэй жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслээ зогсоож, 1714 эмэгтэй шинээр жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж буй нийт 16,297 эмэгтэй (65.1%) байгаа нь оны өмнөх үеэс 419 тохиолдлоор нэмэгдсэн байна. |
| 10 | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь | 50% | 58.4% | 60% | Нөхөн үржихүйн насны 25,030 эмэгтэй байгаагаас урьдчилан сэргийлэх үзлэгт 14,626 буюу 58.4% нь хамрагдсан байна. |
| 11 | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан өсвөр насны хүүхдийн эзлэх хувь | 95,2% | 99.2% | 60% | Сургуульд суурилсан илрүүлэгт 22 сургуулийн 2576 суралцагчаас 2557 (99.2%) хамрагдсан. Илрүүлэгт 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) нь эмчлэн эрүүлжсэн. |
| **Орцын шалгуур** | | | | | |
| 12 | 10,000 хүн амд ногдох эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн харьцаа | 2.1 | 2.1 | 3.4 | БОЭТ-ийн төрөх тасагт 12, Хойд бүсийн хавдар судлалын дэд төвд 2, Баян-Өндөрмед эмнэлэгт 1, СӨЭМТ-д 2, эмэгтэйчүүдийн хувийн клиникт 5 нийт 22 эх барих, эмэгтэйчүүдийн эмч ажиллаж байна. |
| 13 | 10,000 хүн амд ногдох эх бариگчийн харьцаа | 3.2 | 3.2 | 3.5 | БОЭТ-ийн төрөх тасагт 25, сум, өрхийн эрүүл мэндийн төвд 9 нийт 34 эх баригч ажиллаж байна. |
| 14 | 10,000 хүн амд ногдох хүүхдийн эмчийн харьцаа | 1.5 | 1.7 | 2.9 | БОЭТ-ийн хүүхдийн тасагт 8, хойд бүсийн хавдар судлалын дэд төв - 1, Баян-Өндөрмед -1, хүүхдийн 5 клиник, СӨЭМТ-д 2 нийт хүүхдийн 18 эмч ажиллаж байна. |
| 15 | 10,000 хүн амд ногдох нярайн эмчийн харьцаа | 0.5 | 0.5 | 0.5 | БОЭТ-ийн нярайн тасагт 6 нярайн эмч, 11 сувилагч ажиллаж байна. |
| 16 | 5-аас доошгүй нэр төрлийн жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | 100% | 100% | 98% | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад тайлант хугацаанд жирэмслэхээс сэргийлэх эм - 194, тариа - 284, норплант - 114, бэлгэвч - 255, ерөндөг - 771 хүнд олгосон байна. |
| 17 | Жирэмсэн үеийн хооллолт, хоол тэжээл сургалтад хамрагдсан эрүүл мэндийн мэргэжилтний хувь | 54,0% | 60% | 60% | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 33 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд жирэмсэн үеийн хоол тэжээлийн сургалтыг зохион байгуулсан байна. |
| 18 | Эх барихын яаралтай тусламжид сургагдсан эм, эх баригчийн хувь | 72,4% | 85.7% | 80% | АШУҮИС-ын Дархан-Уул аймгийн Эмнэлзүйн тэнхимийн багш нартай хамтран БОЭТ-ийн төрөх тасгийн 22, сум, өрхийн 8 нийт 30 эх баригчид эх барихын яаралтай тусламжийн сургалтад хамруулж чадавхжуулсан байна. |

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Эмнэлгийн тусламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Хишгээ

ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн А.Хонгорзул

Хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Д.Цэрэнлхам